



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Баян өсөх агро” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/003/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор  
2025 оны 03 дугаар сарын 15

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат  
Утас: 70442584 Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)  
Ахлах аудитор: М.Алтантуяа  
Утас: 80112188 Цахим хаяг: [altantuyam@audit.gov.mn](mailto:altantuyam@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Н.Батчимэг  
Утас: 91113253 Цахим хаяг: [batchimegn@audit.gov.mn](mailto:batchimegn@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	9
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	11
4.1 Ерөнхий зүйл .....	11
4.2 Материаллаг байдал .....	12
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
4.4.1 Завсрын аудитын талаар .....	12
4.4.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	12
4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	12
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	14

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ХАА	Хөдөө аж ахуй



“БАЯН ӨСӨХ АГРО” ОНӨААТҮГ-ЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ А.ЭРДЭНЭБИЛЭГ  
ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2025.03.15 № 2/88  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г **Хязгаарлалтай дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Баян өсөх агро” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв томилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тус байгууллага нь үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хийгээгүй, мөн Хөдөө аж ахуйн кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төслийн хөдөө аж ахуйн машин тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Эм эн юу” ХХК-ийн нийлүүлсэн 5 нэр төрлийн 808,800.0 мянган төгрөгийн хөрөнгийг аймгийн ИТХ-ын даргын 2024.11.18-ны өдрийн “Үндсэн хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай” 99 дүгээр захирамжаар орлого авч бүртгэх шийдвэр гарсан байхад санхүүгийн тайланд бүртгээгүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1 дэх “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал

5020444

бүртгэнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна”, 77 дугаар зүйлийн 77.2.3 дахь “Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах ба бусдад шилжүүлэх, шинээр олж авах жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийг хэлэлцэж батлах. Хувьчлах орон нутгийн эд хөрөнгийн жагсаалтыг батлахдаа Төрийн өмчийн хороотой зөвшилцөнө” гэсэн заалтыг зөрчсөн, УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, УСНББОУС-12 Бараа материал, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 дахь “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийн хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. “Баян өсөх агро” ОНӨААТҮГ-ын 2024 онд үйл ажиллагаа явуулаагүй байна.

“Баян өсөх агро” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд тодруулга, толилуулга хийгээгүй байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Б.МӨНХБАТ



הוא יתמוך במימון המבצע, ויבטיח את הצלחתו. ייתכן שיש להתייעץ עם

הרשויות הרלוונטיות לגבי האפשרויות. המבצע יתבצע באמצעות קניית

האמצעים הנדרשים, ויש לוודא שהם יישלמו בזמן. המבצע יתבצע

באופן

המבצע יתבצע באופן המבצע יתבצע באופן המבצע יתבצע באופן

המבצע יתבצע באופן המבצע יתבצע באופן המבצע יתבצע באופן

המבצע יתבצע באופן המבצע יתבצע באופן המבצע יתבצע באופן

המבצע יתבצע באופן

המבצע יתבצע באופן

המבצע יתבצע באופן המבצע יתבצע באופן המבצע יתבצע באופן

המבצע יתבצע באופן

המבצע יתבצע באופן המבצע יתבצע באופן המבצע יתבצע באופן

המבצע יתבצע באופן

המבצע יתבצע באופן

המבצע יתבצע באופן המבצע יתבצע באופן המבצע יתבצע באופן



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>187,459,933.33</b>	<b>187,455,453.33</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>4,480.00</b>	<b>0.00</b>
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,480.00	0.00
31210	Төгрөг	4,480.00	0.00
31213	Арилжааны банк дахь харилцах	4,480.00	0.00
33	<b>АВЛАГА</b>	<b>14,767,333.33</b>	<b>14,767,333.33</b>
33500	<b>Бусад авлага</b>	<b>14,767,333.33</b>	<b>14,767,333.33</b>
33510	Байгууллагаас авах авлага	14,767,333.33	14,767,333.33
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>39,779,120.00</b>	<b>39,779,120.00</b>
34600	Урьдчилж гарсан зардал	39,779,120.00	39,779,120.00
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	<b>132,909,000.00</b>	<b>132,909,000.00</b>
36100	Барааны нөөц	132,909,000.00	132,909,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>187,459,933.33</b>	<b>187,455,453.33</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>40,000,000.00</b>	<b>40,000,000.00</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>40,000,000.00</b>	<b>40,000,000.00</b>
41300	Өглөг	40,000,000.00	40,000,000.00
41360	Бусад өглөг	40,000,000.00	40,000,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	40,000,000.00	40,000,000.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>147,459,933.33</b>	<b>147,455,453.33</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>147,459,933.33</b>	<b>147,455,453.33</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	10,000.00	10,000.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	10,000.00	10,000.00
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>147,449,933.33</b>	<b>147,445,453.33</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	147,459,533.33	147,449,933.33
51220	Тайлант үеийн үр дүн	-9,600.00	-4,480.00
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>187,459,933.33</b>	<b>187,455,453.33</b>

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,000,000.00</b>	<b>0.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,000,000.00</b>	<b>0.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	1,000,000.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,000,000.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	0.00
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,009,600.00</b>	<b>4,480.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,009,600.00</b>	<b>4,480.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,009,600.00</b>	<b>4,480.00</b>
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,009,600.00</b>	<b>4,480.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,009,600.00	4,480.00
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-9,600.00</b>	<b>-4,480.00</b>
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-9,600.00</b>	<b>-4,480.00</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,000.00	0.00	147,459,533.33	147,469,533.33
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,000.00	0.00	147,459,533.33	147,469,533.33
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-9,600.00	-9,600.00
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,000.00	0.00	147,449,933.33	147,459,933.33
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	10,000.00	0.00	147,449,933.33	147,459,933.33
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,000.00	0.00	147,449,933.33	147,459,933.33
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-4,480.00	-4,480.00
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	10,000.00	0.00	147,445,453.33	147,455,453.33

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,000,000.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,000,000.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,000,000.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,000,000.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	0.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,012,600.00	4,480.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,012,600.00	4,480.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,012,600.00	4,480.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,012,600.00	4,480.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,012,600.00	4,480.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-12,600.00	-4,480.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-12,600.00	-4,480.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	17,080.00	4,480.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,480.00	0.00

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймагт малын тэжээл, төмс хүнсний ногоо кластер байгуулах дэд төслийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулагдаж үйлдвэрийн үйл ажиллагаа явуулах "Баян Өсөх Агро" ОНӨААТҮГ байгуулахаар аймгийн Иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар Баянхонгор аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөө, хөдөө аж ахуйг кластераар хөгжүүлэх бодлогод тулгуурлан тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх болон мал аж ахуйн үйлдвэрлэлд цөм сүргийг бий болгох, үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагаа явуулах дүрмийг баталсан байна.

Байгууллагын эрхэм зорилгыг “Баянхонгор аймагт газар тариаланг сэргээж, ХАА-н бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ байгуулах, газар тариалангийн бүтээгдэхүүнийг кластераар хөгжүүлэх, малын цөм сүргийн аж ахуй байгуулах замаар мах, сүү, малын гаралтай чанартай түүхий эд бэлтгэлийн тогтолцоо бий болгох чиглэлд ажиллана” гэж тодорхойлсон байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

ХАА-н кластер төсөл, Малын тэжээл, төмс хүнсний ногооны кластер байгуулах дэд төсөл “Урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл”-ийн 7.2-т “Хүний нөөцийн төлөвлөлт”-д 47 хүний бүрэлдэхүүнтэй 7.3-т “Удирдлага зохион байгуулалтын схем”-д Удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал, 3 хэлтэс, 6 алба, нэгж, тасагтай байхаар тооцоолсон ч 2024 онд үйл ажиллагаа явуулаагүй ба Гүйцэтгэх захирал буюу нэг хүний бүрэлдэхүүнтэй байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүргийг үүргийг Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба тус байгууллагын 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 5 зөвлөмж өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Баян Өсөх Агро” ОНӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайланг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгээгүй байна.

Тус байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

“Баян Өсөх Агро” ОНӨААТҮГ 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 414,117.1 мянган төгрөг ба өмчид өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	17.1	17.1	00.0
Бараа материал	12,000.0	12,000.0	00.0
Үндсэн хөрөнгө	402,100.0	402,100.0	00.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>414,117.1</b>	<b>414,117.1</b>	<b>00.0</b>
Богино хугацаат өр төлбөр	1,597.7	1,597.7	00.0
Урт хугацаат өр төлбөр	40,000.0	40,000.0	00.0
Өмч -Хувийн	10.0	10.0	00.0
Эздийн өмчийн бусад хэсэг	391,000.0	391,000.0	00.0
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(18,490.6)	(18,490.6)	00.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>414,117.1</b>	<b>414,117.1</b>	<b>00.0</b>

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 1,597.7 мянга, урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 40,000.0 мянга, эздийн өмч дансны үлдэгдэл 391,000.0 мянган төгрөг ба өөрчлөлт ороогүй нь тус байгууллага тайлант онд үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотой байна.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Баян Өсөх Агро” ОНӨААТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Баян Өсөх Агро” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

“Баян Өсөх Агро” ОНӨААТҮГ 2024 оны санхүүгийн тайлан, эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/33 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг байгууллагын нийт эргэлтийн хөрөнгө 187,455.5 мянган төгрөгийг дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг байгууллагын нийт эргэлтийн хөрөнгө 187,455.5 мянган төгрөгөөс 5.0 хувиар буюу 9,372.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7,498.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.4.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно

#### 4.4.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар түүвэр аудитад хамрагдсан ба зөрчил илрээгүй байна.

### 4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөдөө аж ахуйн кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төслийн хөдөө аж ахуйн машин тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Эм эн юу” ХХК-ийн нийлүүлсэн 2 нэр төрлийн 292,800.0 мянган төгрөг нь техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангахгүй байгаа асуудлын “Улс, орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар авч үзэх шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 941,709.0 мянган төгрөгийн 3 зөрчил<sup>1</sup> илэрснээс, зөрчлийг арилгах 941,709.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 132,909.0 мянган төгрөгийн материаллаг залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 7,498.2 мянган төгрөгийн материаллаг гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 125,410.8 мянган төгрөгөөр их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 5.2 Албан шаардлага

5.2.1. Тус байгууллага нь эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 132,909.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хийгээгүй байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

“Баян өсөх агро” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, эдийн засгийн зорилтот түвшинд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1 дэх “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; гэсэн заалтыг зөрчсөн байна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Эргэлтийн хөрөнгийн тооллогыг хийж зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.2.2. Хөдөө аж ахуйн кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төслийн хөдөө аж ахуйн машин тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Эм эн юу” ХХК-ийн нийлүүлсэн 5 нэр төрлийн 808,800.0 мянган төгрөгийн хөрөнгийг аймгийн ИХТ-ын даргын 2024.11.18-ны өдрийн “Үндсэн хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай” 99 дүгээр захирамжаар орлого авч бүртгэх шийдвэр гарсан байхад санхүүгийн тайланд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь “Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна”, 77 дугаар зүйлийн 77.2.3 дахь “Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах ба бусдад шилжүүлэх, шинээр олж авах жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийг хэлэлцэж батлах. Хувьчлах орон нутгийн эд хөрөнгийн жагсаалтыг батлахдаа Төрийн өмчийн хороотой зөвшилцөнө” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн Орон нутгийн өмчийн газартай тооцоо нийлж үндсэн хөрөнгийг бүртгэж зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.2.3. Тус байгууллага нь ААНОАТ-ын тайланг санхүүгийн тайлангаас зөрүүтэй илэрхийлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна Санхүүгийн тайланг цахим хэлбэрээр гаргах тохиолдолд цахим гарын үсэг хэрэглэж баталгаажуулна”, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангаа энэ хуулиар тогтоосон хугацаанд харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлэх үүрэгтэй” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ААНОАТ-ын тайланг цахим сайтад үнэн зөв шивж зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллага нь эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 132,909.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хийгээгүй байна.	1	132,909.0	-	-	1	132,909.0	-	-
Хөдөө аж ахуйн кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төслийн хөдөө аж ахуйн машин тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Эм эн юу” ХХК-ийн нийлүүлсэн 5 нэр төрлийн 808,800.0 мянган төгрөгийн хөрөнгийг аймгийн ИХТ-ын даргын 2024.11.18-ны өдрийн “Үндсэн хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай” 99 дүгээр захирамжаар орлого авч бүртгэх шийдвэр гарсан байхад санхүүгийн тайланд бүртгээгүй байна.	1	808,800.0	-	-	1	808,800.0	-	-
Тус байгууллага нь ААНОАТ-ын тайланг санхүүгийн тайлангаас зөрүүтэй илэрхийлсэн байна.	1	0	-	-	1	0	-	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>941,709.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>941,709.0</b>	<b>-</b>	<b>-</b>

-----oOo-----